



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

Үнэн ба зөв намын даргаар
бүртгүүлэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Хосбаяр даргалж, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Н.Баярмаа, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Н.Батзориг, М.Батсуурь, Н.Батчимэг, Э.Золзаяа, Ц.Оч, Т.Өсөхбаяр, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Үнэн ба зөв намын даргаар бүртгүүлэх тухай өргөдлийг Танхимын тэргүүн Д.Мөнхтуяагийн танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Үнэн ба зөв намын үүсгэн байгуулагч А.Отгонбаатараас "... Монгол Улсын дээд шүүхэд 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдөр бүртгүүлсэн Үнэн ба зөв намын дүрэмд намын даргын бүрэн эрхийн хугацааг нийцүүлэх тухай намын Төв хорооны хурал 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдөр болж, намын дүрмийн 6.4-т заасны дагуу намын даргаар А.Отгонбаатарыг сонгосон. Иймд намын даргыг бүртгүүлэх хүсэлт гаргаж, хуульд заасан холбогдох бичиг баримтыг хүргүүлж байна" гэх өргөдлийг 25 хуудас баримт, 1 ширхэг дискийн хамт 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Улсын дээд шүүхэд ирүүлжээ.

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан "Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам"-ын 2.5-д заасны дагуу ирүүлсэн баримт материалуудыг урьдчилан шалгаж, журмын 6.6-д зааснаар нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Үнэн ба зөв намын даргаар Аюурзанын Отгонбаатарыг бүртгүүлэх хүсэлтийг хангаж шийдвэрлэлээ.

Нэг. Намын төлөөллийн төв байгууллага болох Төв хорооны хурлыг зарлан хуралдуулсан талаар:

Үнэн ба зөв намын 2026 оны дүрмийн 5.6-д "Төв хорооны хурлаар хэлэлцэх асуудлыг Байнгын хорооноос оруулж, Төв хорооны хуралдаанаар батлах ...", 5.8-д "Намын Төв хорооны хуралдааныг намын дарга, Байнгын хорооны санаачилгаар, ...

зарлан хуралдуулж болно”, 7.2-т “Байнгын хороо нь намын даргыг оролцуулан 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр Төв хорооны гишүүдийн нууц санал хураалтаар намын Их хурлын бүрэн эрхийн хугацаанд 4 жилийн хугацаагаар сонгоно ...”, 7.3-т “Байнгын хорооны нийт төлөөлөгчдийн олонх нь оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно. Аливаа асуудлыг олонхоороо хэлэлцэн шийдвэрлэнэ”, 8.7-д “Намын дотоод сонгуульд нэр дэвших, санал хураах журмыг намын Их хурал, Төв хороо, байнгын хороо өөрийн бүрэн эрхийн хүрээнд баталж мөрдүүлнэ” гэж тус тус заажээ.

Үнэн ба зөв намын дүрмийн 5.1-д “Намын Их хурал намын Төв хорооны гишүүдийг 21 хүний бүрэлдэхүүнтэйгээр дараагийн Их хурал хүртэлх буюу 4 жилийн хугацаатайгаар байгуулна. Төв хорооны гишүүдийг сонгохдоо намын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, ерөнхий нарийн бичгийн даргыг оролцуулан нэр дэвшүүлж саналыг нууцаар хураана. Төв хорооны гишүүдийн 50-аас доошгүй хувь нь намын анхан дунд шатны байгууллагын төлөөллөөс бүрдэнэ”, 5.4-т “Нийт гишүүдийн гуравны хоёроос илүү нь оролцож байгаа бол Төв хорооны хурлыг хүчинтэйд тооцно” гэж тус тус заасны дагуу Үнэн ба зөв намын Их Хурлын 2026 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоол, Тооллогын комиссын 03 дугаар тогтоолуудаар Төв хорооны гишүүнээр 12 эрэгтэй, 9 эмэгтэй нийт 21 гишүүнийг нууц санал хураалтаар сонгож баталсан байна.

Өргөдөлд хавсаргаж ирүүлсэн баримтуудаас үзвэл, Үнэн ба зөв намын Байнгын хороо 9 гишүүнтэй бөгөөд 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанд Байнгын хорооны 9 гишүүн бүгд оролцсон нь ирүүлсэн баримтаар тогтоогдсон тул тус намын дүрмийн 7.3-т заасан шаардлагыг хангасан, Байнгын хорооны хурал хүчин төгөлдөр, түүнчлэн намын Байнгын хорооны уг хуралдааны 02/13 дугаар тогтоолоор “намын дарга сонгох журам”-ыг баталсан, мөн 02/11 дүгээр тогтоолоор намын Төв хорооны хурлыг 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулахаар товлон зарлаж, хэлэлцэх асуудлыг тогтоосон нь дүрмийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй гэж үзэв.

Байнгын хорооны дээрх хуралдаанаас тогтоосон товын дагуу 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдөр намын Төв хорооны хурал танхимаар зохион байгуулагдаж, хуралд оролцох эрх бүхий 21 гишүүн оролцохоос 21 (100%) оролцсон нь ирцийн бүртгэл, фото зураг, дүрс бичлэг болон бусад баримтаар тогтоогдож байх бөгөөд процессын хувьд зөрчилгүй байна.

Хоёр. Намын Төв хорооны хурлаас намын даргыг сонгож, баталсан талаар:

Намын хувийн хэрэгт хадгалагдаж буй баримтад намын үүсгэн байгуулагчдын хурлыг 2017 оны 03 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж, тус хурлын 06 дугаар тогтоолоор намын даргаар Аюурзанын Отгонбаатарыг сонгосон боловч тухайн үед намын даргыг бүртгүүлэх хүсэлтийг Улсын дээд шүүхэд гаргаагүй, Улсын дээд шүүхийн тогтоолоор тус намын даргаар хэн нэг этгээд бүртгэгдээгүй байжээ.

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.6-д “намын дүрэмд заасны дагуу намын даргыг удирдах дээд байгууллага, эсхүл төлөөллийн төв байгууллага, ... сонгоно” гэж заасан, түүнчлэн Улсын дээд шүүхэд бүртгэлтэй Үнэн ба зөв намын 2026 оны дүрмийн 6.4-т “Төв хорооны хурлаар Намын дарга буюу үүсгэн байгуулагчийн бүрэн эрхийн хугацааг намын дүрэм (Улс төрийн

намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлсэн намын дүрэм)-д нийцүүлэх талаар хэлэлцэж, Төв хорооны гишүүдийн гуравны хоёрын нууц санал хураалтаар дэмжсэн бол намын даргыг дөрвөн жилийн хугацаатай сонгосонд тооцож, Монгол Улсын дээд шүүхэд намын даргыг бүртгүүлнэ” гэж заасан байна.

Намын даргыг бүртгүүлэх өргөдөлд хавсаргаж ирүүлсэн баримтаар Байнгын хорооны 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын 02/13 дугаар тогтоолоор баталсан “Намын дарга сонгох журам”-д заасны дагуу Үнэн ба зөв намын даргыг сонгох үйл ажиллагаа явагдсан, намын даргад Аюурзанын Отгонбаатар нэр дэвшиж, нууц санал хураалтаар “... 21 гишүүнээс 20 (95.3%) нь дэмжиж, 1 гишүүн татгалзсан ...”-аар А.Отгонбаатарыг намын даргаар сонгосон нь 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн Төв хорооны хурлын Тооллогын комиссын 02 дугаар тогтоол, “намын дарга сонгосон тухай” 34 дүгээр тогтоолоор тогтоогдсон, энэ нь дүрмийн 5.11-д “Төв хорооны хурал нь хууль тогтоомж, намын дүрэмд тусгайлан зааснаас бусад аливаа асуудлыг олонхоороо хэлэлцэн шийдвэрлэнэ. Хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх бөгөөд цөөнхийн саналыг хэлэлцэх боломж олгож санал хураалт явуулна” гэж заасантай нийцжээ.

Иймд, Үнэн ба зөв намын Төв хорооны 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн тус намын даргаар Аюурзанын Отгонбаатарыг бүртгэх нь зүйтэй байна.

Монгол Улсын шүүхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.6-д заасныг баримтлан Үнэн ба зөв намын даргаар Аюурзанын Отгонбаатарыг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.ХОСБАЯР

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Д.МӨНХТУЯА